ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

## ПАЛЕОНТОЛОГИЙН ХҮРЭЭЛЭНГИЙН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

**АУДИТЫН КОД: АХГ-2022/59/НА-СТА-ТШЗ**

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу.

**Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг**
**Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn**
**Аудитын менежер: Б.Сэржмядаг**
**Утас: 261628 Цахим хаяг: serjmyadagb@audit.gov.mn**
**Аудитор: Ч.Дашдаваа**
**Утас: 261628 Цахим хаяг: dahsdavaach@audit.gov.mn**
**Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Уваа уул аудит ХХК**
**Захирал: Ч.Мөнхтуяа**
**Цахим хаяг: uvaauul.audit@gmail.com**

Улаанбаатар хот
2022 он

## Агуулга

1. Аудитын гэрчилгээ ........ 3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ........ 5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ........ 5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ........ 7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан........ 10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ........ 12
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан........ 14
3. Аудитын тайлан........ 15
3.1 Ерөнхий зүйл........ 15
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт ........ 15
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ........ 16
3.4 Материаллаг байдал ........ 16
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга ........ 16
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв........ 17
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг ........ 18
3.8 Аудитын гол асуудал ........ 19
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ........ 19
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт........ 19
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт........ 20
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал........ 20
4. Аудитын илрүүлэлт ........ 22
4.1 Залруулсан алдаа ........ 22
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл ........ 23

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |
| БШУС | Боловсрол шинжлэх ухааны сайд |
| ЗГ | Засгийн газар |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| ШУА | Шинжлэх ухааны академи |
| ШУТС | Шинжлэх ухаан технологийн сан |

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ПАЛЕОНТОЛОГИЙН ХҮРЭЭЛЭНГИЙН
ЗАХИРАЛ Х.ЦОГТБААТАР ТАНАА

2022.02.24 № 07/239
танай __________ -ны № __________ -т

Аудитын санал дүгнэлт

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Палеонтологийн хүрээлэнгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Палеонтологийн хүрээлэнгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

\\10.10.10.20\Bichig_Khereg\Yawsan_Bichig\2022\0224 Auditiin 2 Gazar-15.Docx

001050192

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон /төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **207,742,959.49** | **216,252,083.07** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | **10,544,400.43** | **0.00** |
| **31200** | **Банканд байгаа бэлэн мөнгө** | **10,544,400.43** | **0.00** |
| **31210** | **Төгрөг** | **10,544,400.43** | **0.00** |
| 31213 | Арилжааны банкан дахь харилцах | 10,544,400.43 | **0.00** |
| 31215 | Нэмэлт санхүүжилтийн харилцах | 0 | **0.00** |
| **33** | **АВЛАГА** | **17,978,300.00** | **64,548,000.00** |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 40,000.00 | 00.00 |
| 33200 | Төлбөртэй үйлчилгээний авлага | 17,938,300.00 | 60,000,000.00 |
| 33300 | Татаас, санхүүжилтийн авлага | | 4,548,000.00 |
| **34** | **УРЬДЧИЛГАА** | **24,274,431.10** | **21,388,241.70** |
| 34600 | Урьдчилж гарсан зардал | 20,084,000.43 | 15,747,851.60 |
| **34710** | **Урьдчилгаа тооцоо** | **4,190,431.10** | **5,640,390.10** |
| 34711 | Бараа материал бэлтгэх урьдчилгаа | 4,190,431.10 | 5,640,390.10 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **154,945,827.96** | **130,315,841.37** |
| **35100** | **Түүхий эд материал** | **2,946,650.00** | 3,323,544.54 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 2,946,650.00 | 3,323,544.54 |
| **35400** | **Хангамжийн материал** | **151,999,177.96** | **126,992,296.83** |
| 35410 | Бичиг хэргийн материал | 5,163,304.01 | 5,981,645.01 |
| 35420 | Аж ахуйн материал | 110,858,446.28 | 97,424,698.48 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 3,034,000.00 | 1,104,000.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 19,266,030.00 | 7,236,610.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 13,677,397.67 | 15,245,343.34 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **4,457,980,407.60** | **4,309,452,033.08** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **4,457,980,407.60** | **4,309,452,033.08** |
| **39200** | **Биет хөрөнгө** | **4,227,931,877.63** | **4,086,282,753.07** |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,435,240,801.26 | 1,435,240,801.26 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (41,297,837.45) | (75,194,889.05) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 134,310,984.00 | 134,310,984.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (12,928,388.00) | (28,998,716.00) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж(компьютер) | 618,236,547.45 | 650,059,147.45 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (48,226,252.87) | (158,207,781.51) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 66,661,107.36 | 65,394,607.36 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (8,576,569.09) | (18,766,758.81) |
| 39213 | Түүх соёл, музейн дурсгалт зүйлс | 2,065,195,000.00 | 2,065,195,000.00 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 19,003,371.28 | 19,003,371.28 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (3,630,751.36) | (5,696,877.96) |
| 39217 | Ном | 3,943,865.05 | 3,943,865.05 |
| **39300** | **Биет бус хөрөнгө** | **230,048,529.97** | **223,169,280.01** |
| 39301 | Программ хангамж | 20,637,750.00 | 20,637,750.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (7,437,000.03) | (14,316,249.99) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 216,847,780.00 | 216,847,780.00 |
| 39304 | Хуримтлагдсан элэгдэл | 0 | |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **4,665,723,367.09** | **4,525,704,116.15** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **420,327.61** | 5,431,966.99 |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | **420,327.61** | 5,431,966.99 |
| **41300** | **Өглөг** | **420,327.61** | 0.00 |
| **41360** | **Бусад өглөг** | **420,327.61** | 0.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 43,700.00 | 0.00 |
| 41362 | Хувь хүмүүст төлөх өглөг | 376,627.61 | 0.00 |
| 414 | Урьдчилж орсон орлого | 0.00 | 5,431,966.99 |
| 41440 | Бусад урьдчилж орсон орлого | 0.00 | 5,431,966.99 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **4,665,303,039.48** | **4,520,272,149.16** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | **4,665,303,039.48** | **4,520,272,149.16** |

| | | | |
|---|---|---|---|
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 3,649,354,717.94 | 3,649,354,717.94 |
| **51200** | **Хуримтлагдсан үр дүн** | **1,015,948,321.54** | **870,917,431.22** |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 1,015,948,321.54 | 995,119,921.11 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | (124,202,489.89) |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **4,665,723,367.09** | **4,525,704,116.15** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон /төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,857,930,857.95** | **1,220,592,423.01** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **299,784,812.56** | **534,781.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **299,784,812.56** | **534,781.00** |
| 120004 | Төсөвт байгууллагын өөрийн орлого | 285,893,242.56 | 534,781.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 105,000.00 | 175,000.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 285,788,242.56 | 359,781.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө | 13,891,570.00 | - |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,558,146,045.39** | **1,220,057,642.01** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **944,989,600.00** | **898,982,900.00** |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 944,989,600.00 | 898,982,900.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **613,156,445.39** | **321,074,742.01** |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид | - | 22,568,033.01 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 613,156,445.39 | 298,506,709.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)** | **1,583,463,567.15** | **1,343,792,266.90** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,583,463,567.15** | **1,343,792,266.90** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,551,151,815.69** | **1,302,015,863.41** |
| 2101 | Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил | 788,376,867.98 | 667,698,123.61 |
| 210101 | Цалин | 435,104,570.33 | 431,814,864.77 |
| 210102 | Нэмэгдэл цалин | 110,669,776.00 | 93,737,211.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 68,961,500.00 | 57,369,499.83 |
| 210105 | Гэрээтийн цалин | 173,641,021.65 | 84,776,548.01 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **95,524,714.14** | **84,067,424.69** |
| 210201 | Тэтгэврийн даатгалын шимтгэл | 73,445,334.24 | 63,723,258.53 |
| 210202 | Тэтгэмжийн даатгалын шимтгэл | 6,255,173.13 | 5,932,667.40 |
| 210203 | ҮОМШ өвчний даатгалын шимтгэл | 4,940,298.52 | 4,675,573.92 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгалын шимтгэл | 993,073.24 | 885,083.95 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгалын хураамж | 9,890,835.01 | 8,850,840.89 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **11,638,876.26** | **10,730,058.12** |
| 210301 | Гэрэл цахилгааны зардал | 5,819,306.61 | 5,586,393.35 |
| 210302 | Түлш, халаалтын зардал | 4,190,695.65 | 3,268,237.77 |
| 210303 | Цэвэр, бохир усны зардал | 1,628,874.00 | 1,875,427.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **17,660,297.74** | **51,658,043.53** |
| 210401 | Бичиг хэргийн материал | 2,492,205.00 | 5,337,719.00 |
| 210402 | Тээвэр, шатахууны зардал | 11,035,583.00 | 1,893,931.00 |
| 210403 | Шуудан холбоо интернэтийн төлбөр | 855,622.24 | 799,086.97 |
| 210404 | Ном, хэвлэлийн зардал | 1,234,110.50 | 3,278,790.61 |
| 210405 | Хог хаягдал устгах, цэвэрлэх | 1,560,000.00 | 1,560,000.00 |
| 210406 | Бага үнэ түргэн элэгдэл зүйлс | 482,777.00 | 1,823,486.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | - | 36,965,029.95 |
| **2105** | **Нормативт зардал** | **-** | **947,000.00** |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | - | 947,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **41,436,401.00** | **34,501,768.00** |
| 210604 | Урсгал засвар | 41,436,401.00 | 34,501,768.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **11,175,641.53** | **39,493,801.40** |
| 210702 | Дотоод томилолтын зардал | 11,175,641.53 | 39,493,801.40 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж** | **105,336,521.91** | **225,691,315.54** |

| | | | |
|---|---|---|---|
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 102,727,335.91 | 222,929,573.54 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал | 1,000,000.00 | 1,000,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээний төлбөр | - | 106,928.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 272,939.00 | 318,495.00 |
| 210807 | Газрын төлбөр | 1,336,247.00 | 1,336,319.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **480,002,495.13** | **187,228,328.52** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 366,601,620.39 | - |
| 210902 | Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал | 8,853,000.00 | 7,880,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 104,547,874.74 | 179,348,328.52 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **32,311,751.46** | **41,776,403.49** |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 1,900,000.00 | 1,510,000.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 1,900,000.00 | 1,510,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **30,411,751.46** | **40,266,403.49** |
| 213301 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 28,315,762.34 | - |
| 213305 | Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | 2,095,989.12 | 1,678,819.02 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 38,587,584.47 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)** | **274,467,290.80** | **(123,199,843.89)** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)** | **1,405,000.00** | **1,002,646.00** |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | - | 1,002,646.00 |
| 225005 | Үнэ төлбөргүй гарсан зардал | 1,405,000.00 | - |
| **V** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН** | **(1,405,000.00)** | **(1,002,646.00)** |
| **VI** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI=III+V)** | **273,062,290.80** | **(124,202,489.89)** |

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон /төгрөгөөр/

| Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|
| **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **3,649,354,717.94** | **-** | **706,744,734.10** | **4,356,099,452.04** |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0.00 | - | 36,141,296.64 | 36,141,296.64 |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 3,649,354,717.94 | - | 742,886,030.74 | 4,392,240,748.68 |
| **Тайлант үеийн үр дүн** | **0.00** | **-** | **273,062,290.80** | **273,062,290.80** |
| **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **3,649,354,717.94** | **-** | **1,015,948,321.54** | **4,665,303,039.48** |
| **2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **3,649,354,717.94** | **-** | **1,015,948,321.54** | **4,665,303,039.48** |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0.00 | - | (20,828,400.43) | (20,828,400.43) |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **3,649,354,717.94** | **-** | **995,119,921.11** | **4,644,474,639.05** |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | 0.00 | - | 0.00 | 0.00 |
| Тайлант үеийн үр дүн | 0.00 | - | (124,202,489.89 | (124,202,489.89) |
| **2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл** | **3,649,354,717.94** | **-** | **870,917,431.22** | **4,520,272,149.16** |

### 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан /төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,542,102,745.39** | **1,194,499,909.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **1,895,000.00** | **610,000.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **1,895,000.00** | **610,000.00** |
| 120004 | Төсөвт байгууллагын өөрийн орлого | 1,895,000.00 | 610,000.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,895,000.00 | 610,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,540,207,745.39** | **1,193,889,909.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **944,989,600.00** | **898,982,900.00** |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 944,989,600.00 | 898,982,900.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 595,218,145.39 | 294,907,009.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагч | - | 28,000,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 595,218,145.39 | 266,907,009.00 |
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)** | **1,491,813,793.35** | **1,173,221,709.43** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,491,813,793.35** | **1,173,221,709.43** |
| **210** | **БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,459,502,041.89** | **1,116,352,905.51** |
| **2101** | **Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил** | **788,362,960.74** | **667,668,123.61** |
| 210101 | Үндсэн цалин | 435,090,663.09 | 431,784,864.77 |
| 210102 | Нэмэгдэл | 110,669,776.00 | 93,737,211.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 68,961,500.00 | 57,369,499.83 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 173,641,021.65 | 84,776,548.01 |
| **2102** | **Ажил олгочоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **95,524,714.14** | **84,067,424.69** |
| 210201 | Тэтгэврийн даатгалын шимтгэл | 73,445,334.24 | 63,723,258.53 |
| 210202 | Тэтгэмжийн даатгалын шимтгэл | 6,255,173.13 | 5,932,667.40 |
| 210203 | ҮОМШ өвчний даатгалын шимтгэл | 4,940,298.52 | 4,675,573.92 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгалын шимтгэл | 993,073.24 | 885,083.95 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгалын хураамж | 9,890,835.01 | 8,850,840.89 |
| **2103** | **Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал** | **11,638,876.26** | **10,730,058.12** |
| 210301 | Гэрэл цахилгааны зардал | 5,819,306.61 | 5,586,393.35 |
| 210302 | Түлш, халаалтын зардал | 4,190,695.65 | 3,268,237.77 |
| 210303 | Цэвэр, бохир усны зардал | 1,628,874.00 | 1,875,427.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 17,702,231.25 | 41,088,456.97 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,510,600.00 | 5,119,560.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,223,700.00 | 1,890,200.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 855,622.24 | 799,086.97 |
| 210404 | Ном, хэвлэл | 9,927,739.01 | 29,097,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,556,300.00 | 1,563,700.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 628,270.00 | 2,618,910.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **3,996,000.00** | **2,000,000.00** |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 3,996,000.00 | 2,000,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **46,133,301.00** | **35,109,718.00** |
| 210601 | Багаж техник хэрэгсэл | 132,000.00 | - |
| 210604 | Урсгал засвар | 46,001,301.00 | 35,109,718.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 21,428,977.08 | 66,558,757.61 |
| 210701 | Гадаад албан томилолт | - | 10,284,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 21,428,977.08 | 56,274,757.61 |

| | | | |
|---|---|---|---|
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **98,793,361.03** | **201,250,366.51** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж | 95,809,175.03 | 197,393,624.51 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1,000,000.00 | 1,000,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | - | 106,928.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 272,939.00 | 318,495.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 375,000.00 | 1,095,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 1,336,247.00 | 1,336,319.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 375,921,620.39 | 7,880,000.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 366,601,620.39 | - |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 9,320,000.00 | 7,880,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **32,311,751.46** | **56,868,803.92** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **1,900,000.00** | **1,510,000.00** |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 1,900,000.00 | 1,510,000.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 30,411,751.46 | 55,358,803.92 |
| 213301 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 28,315,762.34 | - |
| 213305 | Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | 2,095,989.12 | 6,226,819.02 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 49,131,984.90 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)** | **50,288,952.04** | **21,278,199.57** |
| **V** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)** | **406,346,172.00** | **31,822,600.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **406,346,172.00** | **31,822,600.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | **406,346,172.00** | **31,822,600.00** |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 406,346,172.00 | 31,822,600.00 |
| **VI** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)** | **(406,346,172.00)** | **(31,822,600.00)** |
| **VIII** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)** | **(356,057,219.96)** | **(10,544,400.43)** |
| **101** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | **366,601,620.39** | **10,544,400.43** |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **10,544,400.43** | **0.00** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон /төгрөгөөр/

| Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү |
|---|---|---|---|
| **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | **-** | **10,544,400.43** | **(10,544,400.43)** |
| **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **898,982,900.00** | **861,005,315.53** | **37,977,584.47** |
| **УРСГАЛ ЗАРДАЛ** | **898,982,900.00** | **861,005,315.53** | **37,977,584.47** |
| **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **897,456,100.00** | **859,495,315.53** | **37,960,784.47** |
| Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 601,895,300.00 | 582,891,575.60 | 19,003,724.40 |
| Үндсэн цалин | 433,455,900.00 | 431,784,864.77 | 1,671,035.23 |
| Нэмэгдэл | 96,103,400.00 | 93,737,211.00 | 2,366,189.00 |
| Унаа, болон бусад нөхөн олговор | 72,336,000.00 | 57,369,499.83 | 14,966,500.17 |
| **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **82,066,000.00** | **73,802,115.23** | **8,263,884.77** |
| Тэтгэврийн даатгал | 57,750,100.00 | 53,457,949.07 | 4,292,150.93 |
| Тэтгэмжийн даатгал | 6,079,000.00 | 5,932,667.40 | 146,332.60 |
| ҮОМШӨ ний даатгал | 4,863,200.00 | 4,675,573.92 | 187,626.08 |
| Ажилгүйдлийн даатгал | 1,215,800.00 | 885,083.95 | 330,716.05 |
| Эрүүл мэндийн даатгал | 12,157,900.00 | 8,850,840.89 | 3,307,059.11 |
| **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **14,904,600.00** | **10,730,058.12** | **4,174,541.88** |
| Гэрэл цахилгаан | 4,934,900.00 | 5,586,393.35 | (651,493.35) |
| Түлш, халаалт | 6,849,700.00 | 3,268,237.77 | 3,581,462.23 |
| Цэвэр, бохир ус | 3,120,000.00 | 1,875,427.00 | 1,244,573.00 |
| **Хангамж, бараа материалын зардал** | **14,198,000.00** | **13,552,516.97** | **645,483.03** |
| Бичиг хэрэг | 1,244,400.00 | 1,119,960.00 | 124,440.00 |
| Тээвэр (шатахуун) | 1,890,200.00 | 1,890,200.00 | - |
| Шуудан холбоо, интернэтийн төлбөр | 1,139,300.00 | 799,086.97 | 340,213.03 |
| Ном, хэвлэл | 8,000,000.00 | 8,000,000.00 | - |
| Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,400,100.00 | 1,400,100.00 | - |
| Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс | 524,000.00 | 343,170.00 | 180,830.00 |
| **Нормативт зардал** | **3,600,000.00** | **2,000,000.00** | **1,600,000.00** |
| Нормын хувцас зөөлөн эдлэл | 3,600,000.00 | 2,000,000.00 | 1,600,000.00 |
| Эд хогшил худалдан авах | 66,400,000.00 | 66,222,600.00 | 177,400.00 |
| Багаж, техник, хэрэгсэл | 32,000,000.00 | 31,822,600.00 | 177,400.00 |
| Урсгал засвар | 34,400,000.00 | 34,400,000.00 | - |
| Томилолт, зочны зардал | 8,000,000.00 | 7,823,627.61 | 176,372.39 |
| Дотоод албан томилолт | 8,000,000.00 | 7,823,627.61 | 176,372.39 |
| **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр** | **97,995,600.00** | **94,592,822.00** | **3,402,778.00** |
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 94,395,100.00 | 91,831,080.00 | 2,564,020.00 |
| Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал | 1,000,000.00 | 1,000,000.00 | - |
| Даатгалын үйлчилгээ | 356,600.00 | 106,928.00 | 249,672.00 |
| Тээврийн хэрэгслийн татвар | 650,000.00 | 318,495.00 | 331,505.00 |
| Тээврийн хэрэгслийн оношилгоо | 90,000.00 | - | 90,000.00 |
| Газрын төлбөр | 1,503,900.00 | 1,336,319.00 | 167,581.00 |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 8,396,600.00 | 7,880,000.00 | 516,600.00 |
| Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 8,396,600.00 | 7,880,000.00 | 516,600.00 |
| **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **1,526,800.00** | **1,510,000.00** | **16,800.00** |
| Бусад урсгал шилжүүлэг | 1,526,800.00 | 1,510,000.00 | 16,800.00 |
| Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 1,526,800.00 | 1,510,000.00 | 16,800.00 |
| **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **898,982,900.00** | **861,005,315.53** | **37,977,584.47** |
| **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **898,982,900.00** | **861,005,315.53** | **37,977,584.47** |
| Улсын төсвөөс санхүүжих | 898,982,900.00 | 861,005,315.53 | 37,977,584.47 |

| | | | |
|---|---|---|---|
| **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | **-** | **10,544,400.43** | **(10,544,400.43)** |
| **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **-** | **0.00** | **(0.00)** |
| БАЙГУУЛЛАГЫН ТОО | 1 | 1 | - |
| АЖИЛЛАГСДЫН ТОО | 47 | 47 | - |
| Удирдах ажилтан | 7 | 7 | - |
| Гүйцэтгэх ажилтан | 35 | 35 | - |
| Үйлчлэх ажилтан | 5 | 5 | - |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон /төгрөгөөр/

| ҮЗҮҮЛЭЛТ | ТӨЛӨВЛӨГӨӨ | ГҮЙЦЭТГЭЛ |
|---|---|---|
| **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | | **294,907,009.00** |
| **УРСГАЛ ЗАРДАЛ** | | **294,907,009.00** |
| **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | | **288,680,189.98** |
| **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | | **84,776,548.01** |
| Гэрээт ажлын хөлс | | 84,776,548.01 |
| **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | | **10,265,309.46** |
| Тэтгэврийн даатгал | | 10,265,309.46 |
| **Хангамж, бараа материалын зардал** | | **27,535,940.00** |
| Бичиг хэрэг | | 3,999,600.00 |
| Ном, хэвлэл | | 21,097,000.00 |
| Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | | 163,600.00 |
| Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс | | 2,275,740.00 |
| **Эд хогшил худалдан авах** | | **709,718.00** |
| Урсгал засвар | | 709,718.00 |
| **Томилолт, зочны зардал** | | **58,735,130.00** |
| Гадаад албан томилолт | | 10,284,000.00 |
| Дотоод албан томилолт | | 48,451,130.00 |
| **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр** | | **106,657,544.51** |
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | | 105,562,544.51 |
| Мэдээллийн технологийн зардал | | 1,095,000.00 |
| **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | | **6,226,819.02** |
| **Олгосон санхүүжилт, шилжүүлэг** | | **6,226,819.02** |
| Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | | 6,226,819.02 |
| **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | | **294,907,009.00** |
| **Нэмэлт санхүүжилтийн орлого** | | **294,907,009.00** |
| Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 28,000,000.00 |
| Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | | 266,907,009.00 |

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Палеонтологийн хүрээлэнгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад дансны зааврыг мөрдөж ажиллахтай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 1 дүгээр сарын 25-наас 2022 оны 2 дугаар сарын 25-ны хооронд Уваа уул аудит ХХК-ийн аудитор Ц.Саранцэцэг, аудиторын туслах Э.Номинчулуун, Г.Сампилмаа нар гүйцэтгэж, чанарын хяналтыг Ч.Мөнхтуяа хэрэгжүүлсэн.

Палеонтологийн хүрээлэнгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2022 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн А/07 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Палеонтологийн хүрээлэнгийн үйл ажиллагааны зорилго нь “Эртний шим ертөнц судлалын чиглэлээр онолын суурь судалгаа, судалгаа боловсруулалтын ажлыг орчин үеийн шинжлэх ухаан, техник технологийн түвшинд гүйцэтгэх, Дэлхийн шинжлэх ухааны мэдлэгийн сан хөмрөгт хувь нэмрээ оруулах, нийгэмд шинэ мэдлэг мэдээллийг түгээн дэлгэрүүлэх, судалгаа боловсруулалтын ажлын үр дүнг үйлдвэрлэл практикт нэвтрүүлэн эх орныхоо нийгэм эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулах”-д оршино.

Палеонтологийн хүрээлэн нь Монгол орны эртний тэнгис, нуур ус, эх газрын хурдас чулуулагт хадгалагдаж үлдсэн эртний амьтан, ургамлыг олж илрүүлэх, шинэ төрөл зүйл, биостратиграфийн нэгжүүдийг тогтоох, удам төрлийн харьцаа холбоог нарийвчлан гаргах, филогенезийн судалгааг гүнзгийрүүлэн судлах, эртний амьтан ургамлын судалгааны үр дүнд үндэслэн эртний уур амьсгал, орчныг сэргээн босгох, давхаргазүйн нарийвчилсан судалгааг хийх, биет болон жишиг цуглуулгыг бүрдүүлж Монгол улсын палеонтологийн сан хөмрөгийг баяжуулах, тэдгээрийг музей үзэсгэлэнгийн шугамаар гадаад дотоодод сурталчлах чиг үүрэгтэй үйл ажиллагаа явуулдаг БШУС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх дараах хууль, тогтоомж, бодлого, чиглэлд дараах өөрчлөлт орсон. Үүнд:

- Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”;
- Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаал “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”;
- Сангийн сайдын 2021 оны 102 дугаар тушаалаар батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам";

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил

гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллага нь БШУС-ын “2021 оны бодлогын баримт бичиг, журам батлах тухай” А/26 дугаар тушаалаар баталсан сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагад мөрдөгдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн мөрдөж байга бөгөөд холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын нэгж байхгүй бөгөөд тайлант хугацаанд Боловсрол, шинжлэх ухааны яамны Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газраас шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Палеонтологийн хүрээлэнгийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,583,463.6 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 15,834.6 мянган төгрөгөөр тогтоосон.

Төлөвлөх үе шатанд материаллаг байдлыг Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар тооцсон ба 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн суурь үзүүлэлт нь материаллаг зөрүүтэй буурсан тул шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Аудитыг гүйцэтгэх үе шатанд материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,343,792.3 1 хувиар буюу 13,437.9 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоов.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Палеонтологийн хүрээлэнгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 140,019.3 мянган төгрөгөөр буюу 3.0 хувиар буурч, материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, данстууд байна.
*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|

| Б | 1 | 2 | 3=2-1 |
|---|---|---|---|
| Мөнгөн хөрөнгө | 10,544.4 | 00.00 | (10,544.4) |
| Авлага | 17,978.3 | 64,548.0 | 46,569.7 |
| Урьдчилгаа | 24,274.4 | 21,388.2 | (2,886.2) |
| Бараа материал | 154,945.8 | 130,315.8 | (24,630.0) |
| Үндсэн хөрөнгө | 4,457,980.4 | 4,309,452.0 | (148,528.4) |
| **Нийт хөрөнгө** | **4,665,723.4** | **4,525,704.1** | **(140,019.3)** |
| Өр төлбөр | 420.3 | 5,432.0 | 5,011.7 |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 4,665,303.0 | 4,520,272.1 | 145,030.9 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **4,665,723.4** | **4,525,704.1** | **(140,019.3)** |

Дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Авлага данс 46,569.7 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь:
  - Говийн оюу хөгжлийн дэмжих сантай 200,000.0 мянган төгрөгийн гэрээ байгуулж, тайлант хугацаанд 140,000.0 мянган төгрөгийн санхүүжилт орж, үлдэгдэл 60,000.0 мянган төгрөгийг ажлын гүйцэтгэлийн дагуу хэсэгчлэн шилжүүлэхээр тооцоо нийлж баталгаажуулан, төлбөртэй үйлчилгээний авлагад бүртгэсэн;
  - Шинжлэх ухаан, технологийн сангийн санхүүжилттэй төслийн ажлын 2021 оны санхүүжилтээс зарцуулаагүй үлдэгдлийг улсын төсөвт төвлөрүүлснийг Сангийн яамтай нийт 4,548.0 мянган төгрөгийн тооцоо нийлэн, татаас санхүүжилтийн авлагаар бүртгэсэн;
- Бараа материалын дансны үлдэгдэл 24,630.0 мянган төгрөгөөр буурсан нь Палеонтологийн хүрээлэнгийн захирлын 2021 оны 12 дугаар сарын 24-ний №А/24 тоот тушаалаар нийт 36,965.0 мянган төгрөгийн бараа материалыг акталсан;
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 4,309,452.0 мянган төгрөг болж, 148,528.4 мянган төгрөгөөр буурсан нь тайлант оны элэгдлийн зардлыг 179,348.3 мянган төгрөгөөр тооцоолон бүртгэсэн, төсвийн хөрөнгөөр нийт 31,822.6 мянган төгрөгийн биет ба биет бус хөрөнгийг шинээр худалдан авсан, 1,002.6 мянган төгрөгийн үлдэх өртөгтэй үндсэн хөрөнгийг ШУА-ийн Геологийн хүрээлэнд шилжүүлсэн.
- Өр төлбөр дансны үлдэгдэл 4,419.5 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь ШУТС-аас 2021 онд гурван суурь судалгааны төслийн санхүүжилт 28,000.0 мянган төгрөг орсныг урьдчилж орсон орлого дансанд бүртгэж, 22,568.0 мянган төгрөгийн зарцуулалтыг анхан шатны баримтыг үндэслэн, тооцоо нийлэн хааж, 5,432.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй гарсан,

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус хүрээлэнгийн 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,210,359.1 мянган төгрөг, үүнээс урсгал зардалд 1,210,359.1 мянган төгрөг зарцуулахаар төлөвлөж, төсвийн төслийг дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс урсгал зардлыг 284,521.4 мянган төгрөгөөр бууруулан, 925,837.7 мянган төгрөгөөр баталсан байна.

Төсвийн тодотголоор төсвийн хэмнэлтийн бодлоготой уялдуулан эд хогшил урсгал засварын зардлаас 16,600.0 мянган, хангамж бараа материал, тогтмол зардал, томилолт, бусдаар гүйцэтгүүлсэн, нэг удаагийн тэтгэмжээс 10,254.8 мянга, нийт 26,854.8 мянган төгрөгөөр бууруулан тодотгосон байна.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээнд 898,982.9 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 898,982.9 мянган төгрөгийн санхүүжилт авч, туслах үйл ажиллагааны орлогоор 610,0 мянган төгрөг оруулж, нийт 899,592.9 мянган төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлжээ.

Урсгал үйл ажиллагаанд 871,549.7 мянган төгрөгийг зарцуулж, 38,587.6 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

*Хүснэгт-2 Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөг/

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээний | | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|---|
| | Код | Нэр | | | | |
| **1** | **71805** | **Шинжлэх ухаан, технологи** | **898,982.9** | **861,005.3** | **37,977.6** | **95.8** |
| 1.1 | 80101 | Үндсэн үйл ажиллагааны зардал | 807,328.9 | 771,828.8 | 35,500.1 | 95.8 |
| 1.2 | 80219 | Харуул, хамгаалалтын зардал | 23,887.2 | 23,616.5 | 270.7 | 98.9 |
| 1.3 | 80226 | Байр ашиглалтын үйлчилгээ | 66,240.0 | 64,050.0 | 2,190.0 | 96.7 |
| 1.4 | 80802 | Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал | 1,526,8 | 1,510,0 | 16.8 | 98.9 |

Үндсэн үйл ажиллагааны зардлыг 35,500.1 мянга, харуул, хамгаалалтын зардлыг 270.7 мянга, байр ашиглалтын үйлчилгээ 2,190.0 мянга, ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшууллыг 16.8 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулж, төсвийн нийт зардлын гүйцэтгэл 95.8 хувьтай байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд уул уурхайн 81 компанитай хамтран ажиллах гэрээ байгуулан ажилласны үндсэн дээр 266,907.0 мянган төгрөг, суурь судалгааны төслүүдийн хүрээнд ШУТС-гаас 3 төслийн 28,000.0 мянган төгрөг, нийт 294,907.0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 106,657.5 мянга, цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардалд 84,776.5 мянга, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардалд 10,265.3 мянга, томилолтын зардалд 58,735.1 мянга, хангамж, бараа материалын зардалд 27,535.9 мянга, урсгал засварт 709.7 мянган төгрөгийг зарцуулж, 6,226.8 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлснээс 4,548.0 мянган төгрөгийг авлагаар тусгасан байна.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд дараах онцлог үйл явдлууд болсон байна.Үүнд:

1. "Монгол орны эх газрын цэрдийн экосистем" ном гаргасан. Монгол оронд палеонтологийн судалгаа явагдаж эхэлсэн цагаас өнөөг хүртэл цэрдийн цаг үеийн эртний амьтан, ургамал болон тухайн үеийн эртний экосистемийн талаарх хийгдсэн

олон судалгааны үр дүнд үндэслэн Монгол оронд тархсан эх газрын гаралтай цэрдийн цаг үеийн экосистемийн талаарх цэгцлэн, нэгтгэсэн анхны баримт бичиг болж байгаагаараа онцлог юм.

2. "Фитостратиграфия и флора средне-верхнепермских угленосных отложений Южной Монголии" нэг сэдэвт бүтээл гаргасан. Өмнөговь аймаг дахь дунд хожуу пермийн нүүрст хурдасны эртний ургамлын судалгаанд тулгуурлан нүүрстэй хурдасны давхарга зүйн ангиллын нарийвчилсан схемийг боловсруулжээ.
3. "Шар цав" үлэг гүрвэлийн мөрт газрыг түшиглэсэн хээрийн судалгааны лаборатори, музейг байгуулж эхэлж байна.

Тайлант онд Палеонтологийн хүрээлэнгийн үр дүнгийн талаарх тоон болон чанарын үзүүлэлтэд тусгагдсан хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилт 103.3 хувь, хөтөлбөр, арга хэмжээнд зориулан зарцуулахаар төлөвлөж зарцуулсан төсвийн гүйцэтгэл 95.8 хувийн биелэлттэй, 4.2 хувь буюу 27,433.2 мянган төгрөгөөр зөрүүтэй буюу төсвийг хэмнэлттэй зарцуулж, байгууллагын хүрэх үр дүнд хүрч ажилласан байна.

*Хүснэгт-3 Үр дүн тоо болон чанарын үзүүлэлт*

| Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|
| Хэвлүүлсэн бүтээлийн тоо | 30 | 33 | (3) | 110.0 |
| Боловсруулсан бүтээгдэхүүний тоо | 2 | 2 | - | 100.0 |
| Эрдэм шинжилгээний үндсэн судалгаанд зарцуулах зардлын эзлэх хувь | 22.9 | 22.9 | - | 100.0 |
| **Дундаж хувь** | | | | **103.3** |

### 3.8 Аудитын гол асуудал

2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд материаллаг дүнтэй буруу илэрхийлэл байхгүй байна.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Палеонтологийн хүрээлэн нь 2021 онд нийт 1,449,166.0 мянган төгрөгийн 175 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 175 мэдээллийг бүрэн байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

#### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

“Палеонтологийн хүрээлэнгийн өрөөнүүдийн цонх, сантехникийн засварын ажил”-ын 32,500.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй тендерт “Арвин булан тал” ХХК 31,380.8 мянган

төгрөгийн үнийн саналтайгаар шалгарч, 2021 оны 09 дүгээр сарын 21-ний өдрийн ПХ/202106005 тоот гэрээ байгуулж, ажлыг гүйцэтгэсэн.

“Палеонтологийн хүрээлэнгийн техник боловсруулалт, гистологийн лабораторийн тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл худалдан авах” 28,900.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй тендерт “Юнитра” ХХК 28,798.0 мянган төгрөгийн үнийн саналтайгаар шалгарч, 2021 оны 09 дүгээр сарын 27-ны өдрийн 2021/049 тоот гэрээ байгуулж, худалдан авалтыг хийсэн.

Худалдан авалтыг Татварын цахим системд бүртгэгдсэн төлбөрийн баримттай тулгахад зөрчил илрээгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Төсвийн тухай хууль, НӨАТ-ын тухай хууль, ТБОНӨХБАУХАТХ, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаал болон бусад хууль эрхийн актын хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн байна гэж дүгнэлээ.

### 3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсрын аудитаар нийт 28,222.0 мянган төгрөгийн алдаа зөрчилд 1 зөвлөмж өгсөн ба хэрэгжилтийг жилийн эцсийн аудитаар дахин хянахад зөвлөмжийг хэрэгжүүлсэн байна.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 25,416.2 мянган төгрөгийн төлбөрийн акт, шилэн дансны цахим хуудсанд 30 мэдээг хугацаа хоцроож байршуулсан, 2 мэдээг байршуулаагүй зөрчилд өгсөн 1 албан шаардлага, 23,279.7 мянган төгрөгийн 3 зөвлөмжийн хэрэгжилт 100.0 хувьтай байна.

*Хүснэгт-4* Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Өмнөх оны илрүүлэлт | | Биелэлт | | Зөрүү | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Төлбөрийн акт | 3 | 25,416.2 | 3 | 25,416.2 | 3 | 0.0 | 100.0 |
| Албан шаардлага | 1 | 0.0 | 1 | 0.0 | 1 | 0.0 | 100.0 |
| Зөвлөмж | 3 | 23,279.7 | 3 | 23,279.7 | 3 | 0.0 | 100.0 |
| **Нийт дүн** | 7 | **48,695.9** | 7 | **48,695.9** | 7 | 0.0 | 100.0 |

Шинжлэх ухааны академийн 2020 оны нэгдсэн санхүүгийн тайланд илэрсэн 10,544.4 мянган төгрөгийн зөрчлийн 2021 оны 03-р сарын 25-ны №102/А0160058 САГ-2021/15/СТА-ТТЗ дугаар төлбөрийн актын дүн дээрх зөрчлийн дүнд багтсан болно.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Жил бүр Урьдчилгаа данс /Урьдчилж гарсан зардал, Урьдчилгаа тооцоо, Бараа материал бэлтгэх урьдчилгаа/ үлдэгдэлтэй гардаг учир энэ дансны хаалтыг шалгах шаардлагатай байдаг. Үүнд:

1. “Соёлын өвийг хамгаалах тухай” хуулийн тавдугаар бүлгийн 27 дугаар зүйлийн 8-д заасны дагуу палеонтологийн хайгуул, малтлага, судалгааны ажлын хүрээнд Монгол улсын нутаг дэвсгэрт хайгуул болон ашиглалтын талбайд үйл ажиллагаа явуулдаг уул уурхайн компаниудтай хамтран ажиллах гэрээ байгуулан ажилласны үндсэн дээр гэрээт ажлын орлого, мөн суурь судалгааны төслүүдийн хүрээнд Шинжлэх ухаан технологийн сангаас төслүүдийн орлого ордог. Гэрээнд үндэслэн гаргасан удирдамжийн дагуу уг орлогыг хээрийн судалгааны ажлын томилолт, зочид буудлын, машин түрээсийн зардалд урьдчилан олгож, дараа тайлангаар анхан шатны баримтыг үндэслэн хааж, үлдэгдлийг тооцоо нийлэн баталгаажуулдаг.

2. Палеонтологийн хүрээлэнгийн "Петро стар" ХХК-ийн картанд төсвийн дансны тээвэр шатахууны гүйлгээ болон нэмэлт данснаас гэрээт ажлын томилолтын шатахууны мөнгийг байршуулдаг. Тухайн томилолтын гүйцэтгэл, холбогдох баримтыг үндэслэн, шатахуун бодитоор худалдаж авсан гэж үзэж, бараа материалыг орлогодож, "Петро стар" ХХК-ийн авлагыг бууруулж, тухайн томилолтын тайлан, замын хуудсаар зарцуулалтыг бүртгэдэг.

3. Тус хүрээлэнгийн эрдэмтэд гадаад орнуудад хүрээлэн хооронд байгуулсан гэрээний дагуу судалгаа, боловсруулалтын ажил хийх, мөн эрдэм шинжилгээний хурал, семинарт явах тохиолдолд тийзийн төлбөрийг урьдчилан шилжүүлж, захиалах шаардлагатай байдаг.

Иймээс дээрх асуудлыг дараагийн тайлант хугацаанд анхаарах нь зүйтэй гэж үзлээ.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 319,335.1 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 319,335.1 мянган төгрөгийн алдааг залруулсан.

Илэрсэн алдааг аудитын явцад залруулж, залруулагдаагүй алдаа, зөрчил байхгүй тул Зөрчилгүй дүгнэлт өглөө.

### 4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

- Гэрээт ажлын 238,506.7 мянган төгрөгийн орлогыг мөнгөн сууриар бүртгэснийг;
- Гэрээт ажлын орлого 60,000.0 мянган төгрөгөөр дутуу тусгагдсаныг;
- Өмнөх аудитаар тавигдсан 20,828.4 мянган төгрөгийн төлбөрийн актыг шилжүүлэхдээ Санхүүгийн үр дүнгийн тайланд томилолтын зардлаар тайлагнасныг хасаж тус тус залруулав.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| д/д | Байгууллагын нэр | Аудитын код | Алдаа зөрчлийн утга | Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга | Нийт алдаа, зөрчлийн дүн | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулга | | Акт | | Албан шаардлага | | Хариуцлага тооцох | | Зөвлөмж | |
| | | | | | тоо | Дүн | тоо | Дүн | тоо | Дүн | тоо | дүн | тоо | дүн | Тоо | дүн |
| Санхүүгийн тайлангийн аудитын асуудлаар | | | | | | | | | | | | | | | | |
| 1 | Палеонтологийн хүрээлэн | АХГ-2022/59/НА-СТА-ТШЗ | Гэрээт ажлын орлогыг мөнгөн сууриар бүртгэсэн. | Орлого аккруэл сууриар бүртгүүлж залруулав. | 1 | 238,506.7 | 1 | 238,506.7 | | | | | | | | |
| 2 | Палеонтологийн хүрээлэн | АХГ-2022/59/НА-СТА-ТШЗ | Гэрээт ажлын орлого 60,000.0 мянган төгрөгөөр дутуу тусгагдсан | Орлого аккруэл сууриар бүртгүүлж нэмж тусгуулан залруулав | 1 | 60,000.0 | 1 | 60,000.0 | | | | | | | | |
| 3 | Палеонтологийн хүрээлэн | АХГ-2022/59/НА-СТА-ТШЗ | Өмнөх аудитаар тавигдсан 38,766.7 мянган төгрөгийн төлбөрийн актыг шилжүүлэхдээ Санхүүгийн үр дүнгийн тайланд томилолтын зардлаар тайлагнасан. | Санхүүгийн үр дүнгийн тайлангийн зардлаас хасаж залруулав. | 1 | 20,828.4 | 1 | 20,828.4 | | | | | | | | |
| Санхүүгийн тайлангийн аудитын дүн | | | | | 2 | 319,335.1 | 2 | 319,335.1 | | | | | - | - | | |
| Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал | | | | | | | | | | | | | | | | |
| Нийцлийн аудитын дүн | | | | | - | - | - | - | - | - | | | | | | |
| Нийт дүн | | | | | 2 | 319,335.1 | 2 | 319,335.1 | | | | | | - | | |

ТЭМДЭГЛЭЛ